





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ БИЕЛЭЛТ**

2024 оны 11 дугаар сарын 17-ны өдөр

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Биелэлт
0	1		2		3	4
Нэг.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах						
1.5	Хүүхэд, хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор дүрэм хуулийг албан хаагчдад танилцуулах	2-р улиралд	Эцэг эхийн зөвлөл	ХГБХХГ	<p>Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас 2024 оны 04 сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Хүүхэд хамгааллын багц хуулийн танилцуулга"-д эцэг эхийн зөвлөл болон 5 албан хаагч оролцож хэлтсийн албан хаагчдад хуулийг сурталчилан танилцуулсан.</p>  <p>Хүүхэд хамгааллын үйлчилгээгээр дамжуулан "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчид"-ийн болон эцэг эхчүүдийн сургалтад 5 албан хаагч хамрагдсан. Сургалтыг аймгийн Прокурорын газар, Боловсрол шинжлэх ухааны газар болон МУГБ, доктор(Ph.D), дэд профессор Х.Баавгай зохион байгуулсан.</p>	100%
<p align="center">Гурав.Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагчдын мэдлэг, чавдарыг дээшлүүлэх ажлын хүрээнд</p>						

3.1	Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулах	жилдээ	Эцэг эхийн зөвлөл	ХГБХХГ	<p>Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан "Эцэг эхийн зөвлөлийг чадавхижуулах" сертификаттай сургалтад байгууллагын эцэг эхийн зөвлөлийн дарга Ц.Дүгэрсүрэн, гишүүн Б.Цэрэнням, З.Чагцалмаа нар хамрагдаж, албан хаагчдад хүүхдийн эрх, гэр бүлийн аз жаргал сэдвээр мэдээлэл хүргэн ажилласан.</p> <p>-Хэлтсийн даргын 2024 оны 10 сарын 07-ны өдрийн А/22 тушаалаар Эцэг эхийн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн өөрчилж, даргаар Иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ч.Бүрэнжаргалыг томилон зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.</p>    <p>Хэлтсийн эцэг эхийн зөвлөл нь Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдад "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга"-ыг сурталчлан таниулж, хүүхдийг зодож шийтгэхийн хор хөнөөлийг тайлбарлан сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулав.</p> 	100%
-----	--	--------	-------------------	--------	---	------

-Гэр бүл, эцэг эх, хүүхдүүдийн харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор "Миний мөрөөдлийн баяр" өдөрлөгийг хүүхэд, гэр бүлийн дунд зохион амжилттай зохион байгууллаа. Нийт 34 хүүхдэд гарын бэлэг гардуулсан. Урлаг, сурлага, спортоороо аймаг, улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан А.Отгонтөгс, Д.Баасандулам, Г.Мөнх-Ундрах нарт баяр хүргэж, дурсамж мөнгөн шагналаар урамшууллаа.




-Сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2024 оны 06 сарын 03-ны 02 дугаартай зөвлөмжийг албан хаагчдад танилцуулан, мөрдөж ажиллахыг даалгасан бөгөөд ямар нэгэн зөрчил гараагүй.

-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 3.Чагцалмаа "Электрон тамхи, тамхин бүтээгдэхүүний хэрэглээг таслан зогсоох нь" сэдвээр мэдээлэл сургалт хийсэн.

-Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 84 ой, нэгдсэн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ойн хүрээнд улсын бүртгэлийн ажилтны өдрийг угтан УБЕГ-ын даргын 2024 оны А/158, А/163 дугаар тушаалаар байгуулагдсан Улсын бүртгэлийн ажилтны арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд Хүүхдийн эрхийг хангах зорилгоор байгууллагын албан хаагчдаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй албан хаагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэхээр "Хүүхдийн төлөө" аяныг зохион байгуулж тус аяны хүрээнд хэлтсийн албан хаагчдаас 170000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Тав.Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд

5.3	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зохистой хэрэглээний талаар албан хаагчдыг мэдээллээр хангах	жилдээ	Эцэг эхийн зөвлөл	МТА	<p>Байгууллагын мэдээллийн самбар болон facebook хуудсанд мэдээлэл тавьж, албан хаагчид цахим орчинд хүүхдийг зодож шийтгэхгүй байх, хүүхдээ хүмүүжлийн эерэг аргаар хүмүүжүүлэхийг иргэд, олон нийтэд уриаллаа.</p>  <p>Хэлтсийн МТА Б.Дөлгөөнмөрөн "Кибер аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга зам" сэдвээр албан хаагчдад сургалт мэдээлэл хийж олон нийтийн сүлжээнд хэрхэн хүүхэд, болон өөрсдийн аюулгүй байдлыг хангах талаар мэдээлэлтэй болсон.</p>	100%
<b>Дундаж хувь</b>					<b>100%</b>	

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
 АРХИВЧ *Б. Д. Д. Д.* Ц. Д. Г. Э. С. У. Р. Э. Н  
 ДАРГА *З. Б. Б. Я. Н. Д. У. Г. А. Р.*  
 ХЯНАСАН  
 4611462  
 ГСЭЗ 460 3223010003